

Сүхбаатар аймгийн Дарьганга суманд 1,3-р багт бэлчээрийн зориулалттай, сумын төвд инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргах, засвар үйлчилгээ хийх техникийн тодорхойлолт

Байршил: Сүхбаатар аймгийн Дарьганга сум усжуулах зорилгоор инженерийн хийцтэй 3 худгийн өрөмдлөгийн ажил, 2 худгийн засварын ажлыг хийж гүйцэтгэнэ.

1. 1-р багт шинээр 1 худаг ,
2. 3-р багт шинээр 1 худаг,
3. Сумын төв шинээр 1 худаг,
4. 3-р баг болон 4-р багт худгийн засвар хийх

Ажлын тодорхойлолт

- 1.1 Худгийг шинээр гаргахаас өмнөх ба дараах үеийн гэрэл зургийг нэг цэгээс авч худгийн солбилцолыг нарийвчлан тодорхойлсон байна.
- 1.2 Худгийн цооног өрөмдөх тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага MNS6088:2011 стандартын дагуу өрөмдлөг туршилтын ажлыг явуулах, худгийн усны гахуурга ажлыг бүрэн гүйцэтгэнэ.
- 1.3 Монгол улсын хүнс хөдөө аж ахуйн сайдын, Байгаль орчны сайдын, Сангийн сайдын 2005 оны 07 сарын 15-ны өдрийн 101,189,194 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан Инженерийн хийцтэй худаг уст цэгийг сэргээх засварлах, шинээр гаргах санхүүжүүлэх эзэмших ашиглах нийтлэг журмыг мөрдөнө. Үүнд:
 - Ажлын иж бүрдэл цооног өрөмдөх, цооногийг цэвэрлэх, шавхалт туршилтын ажил, ус шахуурга зэргийг хийж гүйцэтгэх .
 - Цооног өрөмдөхийн өмнө хайгуулын ажлаар устай эсэхийг тогтоосон акт №1-ийг үйлдэнэ.
 - Инженерийн хийцтэй худаг уст цэгийг шинээр гаргаж, гэрээт хугацааны дотор хүлээлгэн өгсөн тухай ажлын хэсгийн акт №2-ыг үйлдэж орон нутгийн өмчид тусгуулах ажлыг зохион байгуулна.
 - Худгийн цооног өрөмдлөгийн ажлын талаархи мэдээллийг өрөмдлөгийн ажлын журналд тэмдэглэнэ.
 - Цооногийн өрөмдлөгийн ажлыг дууссаны дараа шавхалтын ажлыг заавал хийж шавхалтын ажлын журналыг дэлгэрэнгүй үйлдэнэ.
 - Ашиглалтын цооногын техникийн паспортыг хөтөлж эзэмшигчид хүлээлгэн өгнө.
 - Инженерийн хийцтэй уст цэгийг шинээр гаргасан далд ажлын тухай акт №3-ыг үйлдэж сумын ажлын хэсэгт болон эзэмшигчид хүлээлгэн өгнө
 - Инженерийн хийцтэй худгийн усны шахуурга, холбогч хэрэгсэл дагалдах зүйлсийг иж бүрнээр худгийн цооног бүрт суурилуулна. Худгийн усны

шахуурга дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:Гарал үүслийн гэрчилгээтэй үйлдвэрлэгчийн нэр хаяг барааны олон улсын гэрчилгээтэй байх

1.4 Усны химийн болон бактериологийн шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн байна.

Инженерийн хийцтэй худаг шинээр гаргах худгийн техникийн тодорхойлолт болон шаардлага

1. Цооног өрөмдөх, цооногийг тоноглох
 - 1.1 Геофизикийн судалгаа хийж худгийн байршлийг эцэслэн тогтоох
 - 1.2 Цооногын ашиглалтын ундарга 2м²-6м² ус өгөх хүчин чадалтай байна.
 - 1.3 Цооногийн гүн нь 80м-ээс багагүй байна.
 - 1.4 Суултын яндангийн материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна
 - 1.5 Ус өргөх яндангийн диаметр нь 32мм-ээс багагүй материал нь төмөр болон ундны усанд хэрэглэгдэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой ISO стандарт хангасан /хүйтний улиралд тэсвэртэй/
 - 1.6 Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй тоосонцор хольцгүй мөхлөгийн хэмжээ 10-15мм-ээс томгүй байна.
 - 1.7 Тунгаагуурын гүн нь 2м-ээс багагүй
 - 1.8 Худгийн насос орчин үеийн шаардлагад нийцсэн байна.
 - 1.9 Худгийн шавхалт хийж цэвэрлэх хугацаа 72 цагаас багагүй байна.
 - 1.10 Усны чанарын сорилт авах шинжилгээ хийлгэх
 - 1.11 Худгийн цооногийг түр хугацааны тагаар тоноглох

ТОДОРХОЙЛОЛТ ГАРГАСАН:
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО
Утас:96944455,96655449, 99702377